

дуурсгасансан. Тийнхүү япончууд эзэн хаандаа арга буюу ялагдлын гунигт мэдээ илтгэх хэрэгтэй болсон юм.

Зөвлөлтийн анд нөхөд манай эх орныг эзлэн түрэмгийлэгчдийн эсрэг хийсэн шударга дайнд асар их тусламж үзүүлсэн. Тэд манай тэмцлийг өөрсдийнх, манай дайсныг өөрийн дайсан хэмээн үзэж, тулалдаж явлаа. Энхийн тэнгэрийг маань ариун цусаараа мялаасан зөвлөлт нөхдийн гарз хохирол Тайшань уул мэт их гэдгийг хятадын ард түмэн үеийн үед дурсан санах болно.

1949 онд Зөвлөлт нөхөд маань Хятадад үндэсний цэргийн нисэх хүчин байгуулахад туслахаар дахин ирцгээсэн юм. ЗХУ манай орны социалист бүтээн байгуулалтын үйл хэрэгт мэргэжилтэн, материал, техникийн бүхий л бололцоогоороо тусалсан билээ. ЗХУ-ын тусламж сэтгэл харамгүй, өгөөмөр байсан бөгөөд Хятад орон түүхнээ өөр хэнээс ч ийм тусламж авч байсангүй ээ. Энэ тухай манай ард түмэн цаг ямагт дурсан санадаг юм.

Нас хэвийсэн эдүгээ үед та бид найрамдлаа цуцалтгүй сурталчлан, түүнийг эрхэмлэн хүндэтгэж, уламжлан хөгжүүлэх эрхэм гэгээн үйлсэд залуу үеэ хөтлөн хүмүүжүүлэх ёстой билээ!

Зөвлөлтийн зэвсэг нэгт дайчин нөхдөө  
хүндэтгэсэн **У Динчэнь**

«Литературная газета» сонины 1987 оны  
№ 28 орчуулсан **Ч. Батцэцэг**

### **ЗӨВЛӨЛТӨД МОНГОЛЫГ СУД- ЛААЧДЫН ХОЛБОО БАЙГУУЛАГДАВ.**

ЗСБНХУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын институтэд Монгол судлалын салбарт эрдэм шинжилгээний болон практик үйл ажлаар эрхэлж байгаа хүмүүсийг нэгтгэсэн шинжлэх ухаан-олон нийтийн сайн дурын байгууллага болох Бүх Холбоотын Монгол судлаачдын Холбооны зохион байгуулах бага хурал 5-р сарын 27-нд болов.

Манай оронд Монголын хэл шинжлэл, түүх, эдийн засаг, соёлын салбарт явуулах судалгаа шинжилгээг марксист-ленинист арга зүйн үндсэн дээр хөгжүүлэхэд ЗСБНХУ дахь болон Хилийн чанад дахь Монгол судлалын шинжлэх ухааны ололт амжилтыг задлан шинжилж, нэгтгэн дүгнэхэд энэхүү шинээр байгуулагдсан Холбооны үйл ажиллагаа чиглэгдэнэ. Ийм зорилгоор тухайлан, шинжлэх-ухаан мэдээлэлийн материалууд, явуулсан судалгааны дүнгээр өгүүллүүдийн сэдэвчилсэн эмхтгэлүүд хэвлэн нийтэлж байх болно. Мөн эрдэм шинжилгээний залуу халааг өргөтгөн бэлтгэх, өөрийн орны монгол судлалын төвүүдийг өндөр мэргэжилтэй боловсон хүчнээр бэхжүүлэх, эрдмийн хамт олны ажлын арга барилыг боловсронгуй болгох замаар зөвлөлтийн монгол судлалын буй бүхий эрдэм шинжилгээний чадавхийг ашиглах явдлыг сайжруулах хийгээд тэдний үйл ажиллагааг үр ашигтайгаар дагнан мэргэжүүлэх, холбон зохицуулахад чиглэгдсэн арга хэмжээнүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Үүнтэй уялдуулан

монгол судлалын төвүүдийн дагнан мэргэжих чиглэлийг авч хэлэлцээд: Москвад-Монголыг судлах иж бүрэн асуудлууд (түүх, эдийн засаг, хэл бичиг, соёл); Ленинград - сурвалж судлал, хэл шинжлэл, утга зохиол судлал, угсаатны зүй; Улан-Үдэд -сурвалж судлал, хэл бичиг, буддын судлал, түүхийн асуудал; Элистэйд - туульс, хэл бичиг, сурвалж судлал, угсаатны зүйн судлалын асуудал, Эрхүүд - археологи, угсаатны зүй, шинэ, шинэхэн түүх; Новосибирскт - археологийн судалгаа тус тус эрхлэхээр тогтов.

БНМАУ-тай найрамдал, хамтын ажиллагаагаа бүхий л аргаар бэхжүүлэн хөгжүүлэх талаар Зөвлөлт улсын явуулж байгаа бодлогын биелэлт, монголын тухай мэдлэг, социалист байгуулалтандаа монголын ард түмний олж байгаа ололт амжилтыг сурталчлахад уг холбоо тус дэмжлэг үзүүлнэ.

ЗСБНХУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын институтын орлогч захирал ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн Г. Ф. Ким бага хурлыг нээж, ЗСБНХУ-ын ШУА-ийн Хэл шинжлэлийн институтын захирал, ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн В. М. Солнцев илтгэл тавилаа.

Бага хурлаар Монгол судлаачдын холбооны дүрмийг баталж Монголын талаар явуулах эрдэм шинжилгээний иж бүрэн хөтөлбөрийг сайшаав.

Чуулга уулзалтанд оролцогчид Холбооны удирдах байгууллага Ерөнхий хороо, шалган байцаах комисс, ерөнхий хорооны товчоог сонгов. Бага хурал Холбооны 1987 оны ажлын төлөвлөгөөг батлав.

Оросоос **Э. Пунцаг** орчуулав.